

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС
2019 ОНЫ 05 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


2019 оны 06 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 05 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:



Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 4089 ширхгийг шинээр хэвлэн, 586 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 35 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 13 иргэнд хувийн хэрэг шинээр нээж, 22 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн нийт 160 иргэний мэдээллийг цахим архивт оруулсан байна. Мөн гадаадын таван иргэнд регистрийн дугаар олгосон. Үйлчилгээний танхимд 2918 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авчээ. Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд найман иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, зургаан аж ахуйн нэгж, байгууллагын долоон гадаадын иргэний визийн зөвшөөрлийг шийдвэрлэлээ. Нийт 2870 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 2135, 7585-1882 дугаарын утсаар 185, биечлэн 550 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Бээжин, Вена, Хонконг, Шинэ Зеландын өргөмжит консул, Улаан-Үүд дэх консулын ажилтан нарт утсаар болон зургаан удаагийн цахим шуудангаар виз, бүртгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, 22 улсын 33 гадаадын иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.

Цахим визийн зөвшөөрлийн үйлчилгээг 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж тайлант хугацаанд олон улсын хилийн боомт дээрээс “J” ангиллын 60, “B” ангиллын 57 визийн зөвшөөрөл, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 210 визийн зөвшөөрөл, нийт давхардсан тоогоор 327 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 207 аж ахуйн нэгж, байгууллагын 427 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэсэн байна.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 298 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 50 иргэнд визийн зөвшөөрөл, 80 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 213 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 19 иргэний ангиллыг сольж, 23 иргэнд бүртгэл, найман иргэнд хаягийн өөрчлөлт, есөн иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 149 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 05 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад виз олголт 22.2 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 1.0 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 43.1 хувиар, түр ирэгчийн хасалт 2.0 хувиар, визийн сунгалт 1.3 хувиар тус тус өссөн, харин визийн зөвшөөрөл олголт 26.3 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 17.9 хувиар тус тус буурсан байна.


Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг хүний хүсэлтийг шинээр хүлээн авсан ба гурван хүний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт хүргүүллээ. Харьяат болох хүсэлт гаргасан нэг хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Мөн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан нэг улсын таван иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын дөрвөн улсын харьяат болох хүсэлт гаргасан 20 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан. Харьяатаас гарч гадаадын бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан есөн иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт, 40 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан байна.

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 38 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3169 иргэн бүртгэлтэй байна.



Тайлант хугацаанд Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 11 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцүүлэн есөн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунган, хоёр байгууллагын үйл ажиллагаа эрхлэн зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Түүнчлэн дээрх хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан 12 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 05 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 95 төрийн бус байгууллага байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан гадаад улсын нэг гэр бүл нь “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц”-ийн дагуу холбогдох судалгааг эрх бүхий байгууллагаар хийлгүүлээгүй тул хүсэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд буцаан хүргүүлсэн. Гадаад улсын гэр бүлд үрчлүүлсэн нэг хүүхдийн үрчлэлтийн дараах 12 тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.

1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн долоон улсын 38 иргэнийг байгууллагын даргын 13 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын нэг удаагийн тушаалаар гадаадын нэг иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, гурван удаагийн тушаалаар нэг улсын дөрвөн иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 119 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй 17 гадаадын иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаажээ.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг 93 гадаадын иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн хоёр захирамжаар гадаадын хоёр улсын хоёр иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 124 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд 13 удаагийн төлөвлөгөөт, 21 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 203 аж ахуйн нэгж, байгууллага, 1553 гадаадын иргэнийг хамруулсан ба 118 гадаадын иргэн, 90 аж ахуйн нэгж, байгууллага /268 гадаадын иргэн/, гурван уригч иргэн /гурван гадаадын иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 77,350,000 /далан долоон сая гурван зуун тавин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2019 оны 05 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 57.9 хувиар өссөн, харин зөрчил гаргасан гадаадын иргэн 6.3 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 37.7 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 75.0 хувиар тус тус буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тус байгууллагын 2019 оны эхний дөрвөн сарын байдлаарх хэрэгжилтийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдад, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний нэгдүгээр улирлын биелэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 04 дүгээр сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, байгууллагын 2019 оны 04 дүгээр сарын үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад, байгууллагын төв байрны дэргэд цэцэрлэг байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх талаарх хүсэлтийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газрын дарга, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Хан-Уул дүүргийн Засаг даргад тус тус албан бичгээр хүргүүлж ажиллалаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас баталсан “Эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г үндэслэн “Гадаадын иргэн, харьяатын газраас эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г батлан ажиллаж байна.

Байгууллагын даргын 05 дугаар сарын 09-ний өдрийн А/173 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах, гамшгийн үед ажиллах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, гамшгаас хамгаалах болон газар хөдлөлтийн гамшгийн үед байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх зорилгоор байгууллагын даргын гурван удаагийн удирдамжийн дагуу байгууллагын төв болон Сэлэнгэ, Дорноговь аймагт байрлах албаны албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн үйл

ажиллагаанд холбогдох дүрэм, зааврын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаад хяналт тавин ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх шинэчилсэн журам”-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх, цэгцлэх ажил хийгдэж байна.

Байгууллагын 2020 оны төсвийн төсөөллийг батлуулахтай холбогдуулан 2020 онд хилийн боомт, орон нутагт ажилласан таван жилийн урамшуулал авах хяналтын улсын байцаагч, тэтгэвэрт гарах хугацаанд хүрэх албан хаагчийн судалгааг гарган холбогдох нэгжид хүргүүлсэн.

Мөн байгууллагын даргын 2019 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай” ажлын хэсгээс тус байгууллагын төрийн захиргааны 52 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны тухай хууль болон тус хуульд холбогдох дүрэм, журмын дагуу эцэслэн боловсруулж, хянуулахаар Төрийн албан зөвлөлд хүргүүлээ.

Байгууллагын даргын 2019 оны Б/111 дүгээр тушаалын дагуу төв болон орон нутаг дахь газрын 12 албан хаагчийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагч бэлтгэх сургалтад хамруулан, танхимын 40 цаг, дадлагын 45 цагийн сургалтыг холбогдох албан хаагчид хуваарийн дагуу орж, шалгалтыг зохион байгуулснаар шалгалтад тэнцсэн албан хаагчдад хяналтын улсын байцаагчийн эрхийг олгосон.

Албан хаагчдын мэдээллийн цагаар Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын хүний нөөцийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн О.Болор-Эрдэнэ “Төрийн албаны нөөц бүрдүүлэх журам”, Сургалт судалгаа мэдээллийн нэгдсэн сан хариуцсан мэргэжилтэн Б.Гончигсумлаа “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” сэдвээр сургалт зохион байгуулж байгууллагын төвийн 75 албан хаагч хамрагдаж, орон нутаг дахь газрын 42 албан хаагчдад онлайн хэлбэрээр тус тус хүргэлээ. Мөн Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын ахлах мөрдөгч, хошууч Б.Мандухай “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, байгууллагын төвийн 67 албан хаагч хамрагдаж, орон нутаг дахь газрын 42 албан хаагчдад онлайн хэлбэрээр тус тус хүргэсэн.

Удирдлагын академиас зохион байгуулсан “Байгууллагын гадаад харилцаа, дипломат ёслол” сэдэвт сургалтад Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн, Бүгд Найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага “КОЙКА”-ийн урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсад Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын чадавх бэхжүүлэх” сургалтад тус байгууллагын 11 албан хаагч тус тус хамрагдаж сертификат гардан авсан.

Бүгд Найрамдах Тажикстан Улсад 06 дугаар сард зохион байгуулагдах “Удирдагч эмэгтэйчүүдийг чадавхжуулах 24 дэх удаагийн сургалт”-д оролцох албан хаагчийн визний материал болон оролцох өргөдлийг холбогдох албаны хүмүүст цахим хаягаар илгээлээ.

Визийн зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч эхэлсэнтэй холбогдуулан Виз, зөвшөөрөл, харьяатын газрын мэргэжилтнээс тодруулга авч англи, монгол хэлээр ярилцлага бэлтгэн өдөр тутмын гурван сонин, найман цахим хуудаст, Гадаадын иргэн Монгол Улсын харьяат болох асуудлаар Виз, зөвшөөрөл, харьяатын газрын ахлах мэргэжилтнээс тодруулга авч, ярилцлага бэлтгэн өдөр тутмын нэг

сонин болон олон нийтийн цахим хуудсаар мэдээлсэн. Мөн цахимаар визийн зөвшөөрөл хүсэх видео зааварчилгааг бэлтгэн байгууллагын цахим хуудаст байршуулан ажиллалаа.

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт “Гадаадын иргэдийг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Виз зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах” сэдвийн хүрээнд холбогдох албан хаагчид оролцож мэдээлэл өглөө. Нэвтрүүлгүүдийг бүрэн эхээр байгууллагын хуудаст байршуулан олон нийтэд хүргэсэн.

Байгууллагын архивын ажлын үндсэн зааварт заасны дагуу байгууллагын архивын хосгүй үнэт баримтыг тодорхойлон уйгаржин монгол бичгээр бичигдсэн Монгол Улс гадаадаас ажиллах хүч авах, мөн гадаадын иргэдийн бүртгэл хийж байсан талаарх 23 биет үзмэр, байгууллагын тусгай төрлийн баримт болох 100 ширхэг хатуу диск /DVD/, 28 ширхэг дүрс бичлэгийн хуурцаг, 7 ширхэг зургийн цомгийг тус тус бүртгэлжүүлэн ажиллалаа.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 50 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 43 өргөдөл шийдвэрлэгдэж, 7 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газар болон Төв аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд хамтран ажиллах тухай “Санамж бичиг”-ийн төслийг боловсруулан холбогдох нэгжид хүргүүлсэн.

Дэвшин томилогдохоор нэр дэвшсэн долоон албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, шинээр томилогдсон дөрвөн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулав.

“Гадаадын иргэн, харьяатын газраас Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцыг нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлээ.

Байгууллагын даргын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Канад Улсын Элчин сайдын яамны Хил хамгаалах байгууллагын төлөөлөгч болон консул Анна Мария Койтю, Монгол Улсад суугаа Бүгд Найрамдах Турк Улсын Элчин Сайдын яамны гуравдугаар нарийн бичгийн дарга Мурат Анил нарыг байгууллагадаа хүлээн авах уулзалтыг тус тус зохион байгуулан ажиллав. Мөн тус байгууллагын Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга, консул Кил Кан Мук-тай уулзан цаашид хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд “E-Visa” системийн нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд лавлагаа, мэдээллийн нэмэлт хэсгийг шинээр үүсгэн ажиллагаанд оруулахад бэлэн болгов.

Байгууллагын цахим хуудасны нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд архив цэсийг шинээр нэмж холбогдох мэдээллийг орууллаа. Мөн өргөдөл, гомдлын цэсийг шинэчлэн ажиллагаанд оруулсан.

2.4. Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 04 дүгээр сарын мэдээг Үндэсний аюулгүй байдлын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2019 оны 04 дүгээр сарын байдлаар хяналт тавин 77 мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ач холбогдолтой хугацаанд байршуулсныг нягталж үзэхэд хэрэгжилт 100 хувьтай байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/65 дугаар тушаалын дагуу байгууллагын даргын 2019 оны А/165 дугаар тушаалаар байгууллагын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийх, дахин хуваарилах, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан холбогдох хууль тогтоомжийг судлан, ерөнхий нэг, үндсэн дөрөв, дэд таван чиг үүргийг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хэрхэн тусгасныг аргачлалын дагуу гарган танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн яамны техникийн ажлын хэсэгт танилцуулсан.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Агаарын замын боомт хариуцсан газар, Дорноговь аймаг дахь газар, Хил хамгаалах ерөнхий газрын 0218, 0108 дугаар ангийн албан хаагчдад “Монгол Улсын виз олгох, Монгол Улсад оршин суух болон бүртгэх журам” сэдвээр сургалт зохион байгуулж, харилцан санал солилцлоо.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын хилээр 129 орны 89255 гадаадын иргэн хил нэвтэрснээс түүвэрчилж 300 гадаадын иргэдийн хил нэвтрэлтэд хяналт тавихад Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй иргэний орох визгүй нэг зөрчил илрүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 22 дугаар захирамжийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын ордонд зохион байгуулсан хоёр удаагийн хуралд байгууллагын дарга, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга оролцож, тус хурлаас өгсөн чиглэл, мэдээллийг байгууллагын даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар байгуулагдсан “Торгоны зам” авто ралли уралдаанд оролцогч гадаадын иргэний хил нэвтрэлт, виз, зөвшөөрлийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг”-ийн гишүүдэд танилцуулсан.

2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6.27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 05 дугаар сард 2.81 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 2.38 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2019 оны 05 дугаар сарын байдлаар 1 тэрбум 851 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 531.3 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 70,1 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Багаж техник, хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан “Блүүмвейв” ХХК-аас 132.700.000, нормын хувцасны тендерт шалгарсан “Би энд Би Эс” ХХК-аас 14.630.000, “Амно фейшн” ХХК-аас 36.520.000, “Батзүү” ХХК-аас 7.125.000 төгрөгийн бараа, материал, хувцас хэрэглэлийг гэрээнд заасны дагуу хүлээн авсан.

2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Монгол Улсын Шадар сайдын 2019 оны “Сургалтад оролцуулах тухай” 34 дүгээр тушаалын дагуу Замын-Үүд-Эрээн хотын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулсан сургалтад Дорноговь аймаг дахь газрын дарга хамрагдсан.

Дорнод аймгийн Тагнуулын газраас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай” сургалтад Дорнод аймгийн Зүүн бүс дэх газрын хоёр албан хаагч, Ховд аймгийн Тагнуулын газраас зохион байгуулсан “Байгууллагын нууц болон хувь хүний нууцын тухай ерөнхий ойлголт, мэдээллийг хамгаалах, хуулиар хамгаалагдсан байгууллагын болон хувь хүний нууцыг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах, хариуцлагын тухай” сургалтад Ховд аймгийн Баруун бүс дэх газрын найман албан хаагч тус тус хамрагдлаа.

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь агаарын замын боомтын ирэгч, явагчийн танхимд байрлах тус байгууллагын харьяа хоёр өрөөнд албаны үйл ажиллагаанд тавих зорилгоор хяналтын видео камер суурилуулж ажиллагаанд оруулсан. Мөн Чингис хаан олон улсын нисэх буудалд үйл ажиллагаагаа явуулдаг хууль хяналтын байгууллагууд хамтран зохион байгуулсан “Иргэн таны төлөө-Мэргэжлийн хяналт”, “Зөв тусгал” нээлттэй хаалганы өдөрлөгт тус тус оролцож байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар олон нийтэд сурталчлав.

Түүнчлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын 28.7 сая төгрөгийн санхүүжилтээр Дорноговь аймаг дахь газрын албаны байрын дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгүүлээ.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР